

**УУЛ УУРХАЙ, БАРИЛГА, ЗАМЫН МАШИН ЭЗЭМШИГЧДИЙН ХОЛБОО**

# **АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ**

**ЗАМ, БАРИЛГЫН МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАРЧИН**

**ЗАМ, БАРИЛГЫН ӨРГӨХ, ТЭЭВЭРЛЭХ МАШИН ТӨХӨӨРӨМЖИЙН  
ЗАСВАРЫН ТЕХНИКЧ**

**УЛААНБААТАР 2016**

**АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ  
ЗАМ, БАРИЛГЫН МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАРЧИН  
(II ТҮВШИН)**

**1. Ажлын байрны тодорхойлолт**

Зам барилгын машин, тоног төхөөрөмжийн найдварт ажиллагааг ханган, ашиглалтын хугацааг нэмэгдүүлэхийн тулд хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны шаардлага дүрэм журмыг баримтлан машин техникийн гэрэл, дохионы ажиллагаа, хөргөлтийн шингэн, шатах, тослох материалын нэвчилт, дугуйт болон гинжит явах анги, ажлын төхөөрөмжид үзлэг хийж шаардлагатай үйлчилгээ хийнэ.

Монгол Улсын Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт дахь мэргэжлийн индекс	СТ7233-11
Олон улсын ажил мэргэжлийн ангилал	СТ7233-11
Боловсруулсан огноо	2016 оны 09 – р сарын 21
Баталсан байгууллага	Уул уурхай, барилга замын машин эзэмшигчдийн холбоо
Баталсан огноо	2016 оны 12 – р сарын 21
Хянан засварлах хугацаа	YAMAT – д өөрчлөлт орох бүр, эсвэл 2 жил тутам

**2. Ажлын байрны тухай мэдээлэл**

**2.1. Ажлын байрны нөхцөл, тавигдах шаардлага**

- Завсарчины ажлын байранд тухайн ажилбарыг гүйцэтгэхэд шаардлагатай хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагын дагуу гаргасан ажлын талбай, гэрэлтүүлэг, дулаацуулга, агааржуулалт, дуу чимээ, тоосжилт хэвийн хэмжээнд байна.
- Технологийн картын дагуу шаардагдах технологийн тоног төхөөрөмж, багаж, нэмэлт хэрэгсэлээр иж бүрэн тоноглогдсон байна.
- Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны болон галын аюулгүйн анхааруулах тэмдэг санамж тавигдсан байна.
- Зам барилгын машины агрегат, зангилаа, эд ангийг задалж, засвар хийх нөхцөлд технологийн угаалга, тоосгүйжүүлэх ажилбарыг заавал хийх шаардлагатай.
- Тоос шороо утаа зэрэг гадны нөлөөгүй галын аюулгүй байдлыг хангасан орчинг бүрдүүлэх ба сэлбэг, эд ангиудыг хадгалах тавиур болон шүүгээ тавигдсан байна.

- Шалны гадаргууг тос болон хөргөх шингэн чийгэнд тэсвэртэй материалаар өнгөлж тэгшилсэн байна.

## **2.2. Хөдөлмөр эрхлэлт ба тавигдах шаардлага**

18 нас хүрсэн эрүүл мэндийн үзлэгээр орсон ХАБЭА-н зааварчилга сургалтанд хамрагдаж суусан Монгол улсын Хөдөлмөрийн яам Мэргэжлийн холбооноос баталсан ажил мэргэжлийн түвшингийн 2-с доошгүй зэргийг хангасан мэдлэг ур чадварыг эзэмшсэн мэргэжилтэй ажилчин байна.

Зам барилгын машины засварчины ажлын нөхцөлд ажлын 8 цагаас илүүгүй ажиллах ба Эрэгтэй хүн 20 кг илүүгүй эмэгтэй хүн 10 кг илүүгүй хүнд эд ангийг өргөж суурилуулж ажиллах ба илүү гарсан жинтэй ачааг өргөн тээвэрлэх машин төхөөрөмжөөр хангагдсан байна.

### **2.2.1. Албан боловсрол**

Суурь ба түүнээс дээш боловсрол эзэмшсэн хүн

Мэргэжлийн сургалтад хамрагдсан хүн

### **2.2.2. Мэдлэг**

- Хөдөлмөрийн хууль байгууллагын дотоод журам
- Зам барилгын машин, тоног төхөөрөмжийн засварчны ажлын байрны аюулгүй ажилгааны дүрэм журам, ажлын байрны зохион байгуулалтын онцлог
- Цэвэрлэгээний бодисын зориулалт, ашиглах заавар
- Түлхүүр багаж, хэмжээст түлхүүрний зориулалт ашиглалт
- Машин механизмыг зүгшрүүлэх, тохируулах арга
- Машин механизмд мото цагийн техник үйлчилгээ
- Кинематик, цахилгаан, гидравлик, пневматик схем, тэмдэглэгээ

### **2.2.3. Ур чадвар**

- Хөдөлмөрийн хууль байгууллагын дотоод журам холбогдох зааварчилгааг судалж хүлээн зөвшөөрсөн байх
- Зам барилгын машин, тоног төхөөрөмжийн засварчны ажлын байрны аюулгүй ажилгааны дүрэм журам, ажлын байрыг зохион байгуулах
- Машин механизмыг жолоодон техник үйлчилгээ, засвар хийх постон дээр байрлуулах
- Цэвэрлэгээний бодисын зориулалт, ашиглах зааврыг мөрдөх
- Даралтаар ажилладаг шингэний ба хийн дамжуулагатай багажыг ашиглах
- Түлхүүр багаж, хэмжээст түлхүүрний зориулалт ашиглалтын дагуу ашиглах

- Машин механизмыг зүгшрүүлэх, тохируулах
- Машин механизмд мото цагийн техник үйлчилгээ хийх
- Машин механизмд мото цагийн засварын гарыг авлага ашиглах
- Кинематик, цахилгаан, гидравлик, пневматик схем, тэмдэглэгээг унших
- Ажлын байранд гарах бэртэл, гэмтэлд анхан шатны тусламж үзүүлэх
- Аливаа машин, тоног төхөөрөмжийн ажиллагааг хурдан эзэмших, ажлын байранд тээвэрлэх
- Шинэ техник технологи, багаж хэрэгсэл эзэмших
- Автомашины гэрэлтүүлэх системд техник үйлчилгээ хийх
- Автомашины бусад цахилгаан тоноглолд техник үйлчилгээ хийх
- Хөргөлтийн системийн техник үйлчилгээ, засвар хийх
- Явах ангид техник үйлчилгээ хийх
- Ажлын төхөөрөмжид техник үйлчилгээ, засвар хийх

#### 2.2.4. Хандлага

- Ээлжийн ахлагчийн өгсөн үүрэг даалгаварыг мөрдөж ажиллах
- Үнэнч шударга байх
- Ажлын багийн гишүүд, хамт олонтой эелдэг боловсон харьцдаг байх
- Мэдлэг мэргэжлийн хувьд өсөх, дэвших сонирхолтой байх
- Бүтээлч сэтгэлгээтэй байх
- Ажлын гүйцэтгэлд хариуцлагатай ханддаг байх
- ажлын ачаалал даах
- Харилцаа
- Асуудал шийдвэрлэх
- Багаар ажиллах
- Хувийн менежмент
- Санаачлагатай, овсгоотой байх

#### 2.3. Хүлээх хариуцлага

Хэний өмнө хариуцлага хүлээх	Инженер, механик ээлжийн ахлах
Удирдан ажиллах ажилтан	Ээлжийн ахлагч

#### 2.4. Мэргэжил дээшлүүлэх болон хувиараа хөдөлмөр эрхлэх боломж

Холбогдох албан тушаалууд	Хөгжих дэвших боломж			Тусгай тэмдэглэл
	бага	дунд	өндөр	
Гүйцэтгэх албан тушаал	х			
Удирдах албан тушаал				байхгүй
Өөр төрлийн ажил үүрэг гүйцэтгэх боломж	х			
Хувиараа хөдөлмөр эрхлэх	х			

## 2.5. Үүрэг хариуцлага ба гүйцэтгэх ажлын даалгаврын жагсаалт

Үүрэг	Ажилбар
<b>Ажлын бэлтгэл хангах төлөвлөлт бэлтгэл ажил хийх</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Нэг бүрийн хамгаалах хэрэгсэлийг бүрэн өмссөн байх</li> <li>- Аюулгүй ажилгааны дүрэм зааварт нийцүүлэн мөрдөж ажиллах</li> <li>- Ээлжийн ахлагчаас тухайн өдрийн хуваарьт орсон техник үйлчилгээ, засвар ажлын даалгаврыг авна</li> <li>- Засварын ажлын даалгаварт бичигдсэн (тухайн машин, техникийг хариуцсан операторын өгсөн мэдээллэх хуудасны дагуу) анхааруулгыг тусгаж ажиллах</li> <li>- Тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай техникийн бичиг баримт, ашиглалтын заавартай танилцан ажлаа төлөвлөж бэлтгэлээ хангах</li> <li>- Шаардлагатай бол тэмдэг тэмдэглэгээ, анхааруулах самбар байрлуулах, цоожлох, пайзлах арга хэмжээ авах</li> <li>- Засварын ажилд шаардлагатай багаж, хэрэгслийг сонгох</li> <li>- Засварын ажилд хэрэглэгдэх шалгаж тохируулах, задалж угсрах механик, цахилгаан, хийн ажиллагаатай төхөөрөмжийг ажилд бэлэн болгох</li> </ul>
<b>1. Засварчны ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангаж ажиллах</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулийг ажлын байранд мөрдөж, хэрэгжүүлэх</li> <li>- Засварчны ажлын байран дахь тоног төхөөрөмж, засварын багажны ашиглалт, аюулгүй ажиллагаа</li> <li>- Засварчны ажлын байрны аюулгүй ажиллагааны журам</li> <li>- Засварчны хувийн хамгаалах хэрэгслийн үүрэг, зориулалт, ашиглах аргачлал</li> </ul>
<b>2. Автомашины гэрэлтүүлэх системд техник үйлчилгээ хийх</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Автомашины гэрэлтүүлэх системийг судлах</li> <li>- Гэрэлтүүлэх системийн эд ангийг задлаж, угсрах</li> <li>- Гэрэлтүүлэх системийн схем, тэмдэг тэмдэглэгээг унших</li> <li>- Эргэх дохио болон ослын дохионы гэрлийн ажиллагааг шалгах, оношлох</li> <li>- Манан, ухрахын болон бүхээгний гэрлийн ажиллагааг шалгах, оношлох</li> </ul>
<b>3. Автомашины бусад цахилгаан тоноглолд техник үйлчилгээ хийх</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Автомашины цахилгаан тоноглолын төрлийг судлах</li> <li>- Цахилгаан тоноглолын схем, тэмдэг тэмдэглэгээг унших</li> <li>- Цахилгаан тоноглолын ажиллах зарчмыг судлах</li> <li>- Шил арчигч, шил угаагчийн ажиллагааг шалгах</li> <li>- Хаалганы шил өргөгч, Цан арилгагчийн ажиллагааг шалгах</li> <li>- Төв цоожлогч, Цахилгаан удирдлагатай толь, суудалны ажиллагааг шалгах</li> </ul>
<b>4. Хөргөлтийн системд техник үйлчилгээ хийх</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Хөргөлтийн шингэний түвшинг шалгах, хөлдөлтийн температурыг тодорхойлох, солих</li> <li>- Хөргөлтийн системийн эд анги, ажиллагааг шалгах</li> <li>- Усны насос, термостат, радиатор, сэнс шалгах</li> <li>- Хөргөлтийн системийн шингэний дамжуулах уян хоолой, салоны халаалтын радиаторыг шалгах</li> <li>- Хөргөлтийн системээс хий авах</li> <li>- Усны насос, термостат, радиатор, сэнс шалгах, солих</li> </ul>

<p><b>5. Явах ангид техник үйлчилгээ хийх</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Гинжит ба хийн дугуйт явах ангид гадна угаалга хийх</li> <li>- Явах ангийн арал техник үйлчилгээ хийх</li> <li>- Гүүшинд техник үйлчилгээ хийх</li> <li>- Хийн дугуйнд техник үйлчилгээ хийх</li> <li>- Хийн дугуйн өнхрөлтийн холхивчны чангалагааг шалгах, тохируулах</li> <li>- Гинжит явах ангид техник үйлчилгээ хийх</li> <li>- Гинж чангалах, тохиргоо, тосолгоо хийх</li> </ul>
<p><b>6. Ажлын төхөөрөмжид техник үйлчилгээ хийх</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Ажлын төхөөрөмжид наалдсан шавар шороо цэвэрлэх</li> <li>- Ажлын төхөөрөмжид гадна үзлэг хийх</li> <li>- Ажлын төхөөрөмжид угаалга хийх</li> <li>- Эд ангид тосолгоо хийх</li> <li>- Гэмтэлтэй эд ангийг оношлох</li> </ul>
<p>Ажлын гүйцэтгэлээ мэдээллэх</p>	<p>Техник үйлчилгээ, засвар хийсний дараа тухайн узель зангилааны техникийн төлөв байдал норматив хэмжээнд хүрсэн эсэхийг нотлох</p> <p>Техник үйлчилгээ, засварын бүртгэлийн дэвтэр дээр хийсэн ажил, сольж тавьсан эд анги, узель зангилааны талаар бичилт хийнэ</p> <p>Ээлжийн ахлагч болон машин, төхөөрөмж хариуцсан операторт техник үйлчилгээ, засварын ажлын даалгаварт өгөгдсөн ажлын биелэлтийг мэдээллэх</p> <p>Техник үйлчилгээ, засвар хийж дууссаны дараа пайз, цоож, анхааруулах тэмдэг тэмдэглэгээг авах</p>

## 2.6. Эрх мэдэл ба хариуцлага

<p>Эрх мэдэл</p>	<p>Техник үйлчилгээ засварын ажил хийхэд шаардлагатай багаж хэрэгсэл, сэлбэг материал, нэг бүрийн хамгаалах хэрэгсэлээр хангуулахыг шаардах</p> <p>Хийж гүйцэтгэсэн техник үйлчилгээ, засварын ажлын гүйцэтгэлд үнэлгээ дүгнэлт гаргуулах, түүнтэй танилцах</p> <p>Хос мэргэжил эзэмших чадамжийн сургалтанд хамрагдах өөрийн мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэжлийн зэрэг ахиулах сургаланд хамрагдах хүсэлт гаргах тус тус эрхтэй</p>
<p>Хариуцлага</p>	<p>Техник үйлчилгээ, засварын ажлын технологийн дараалал зөрчих</p> <p>Тос тосолгооны материал буруу сонгох, дутуу хийх, хэмжилт тохируулга буруу хийснээс алдаа гаргах</p> <p>Засварын цех, ажлын байрны аюулгүй ажилгааны дүрэм журмыг зөрчих</p> <p>Ээлжийн ахлагчийн өгөгдсөн үүрэг даалгаврыг графикт хугацаанд хийгээгүй тохиолдолд тус тус хариуцлага хүлээнэ</p>

**АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ  
ЗАМ, БАРИЛГЫН МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАРЧИН  
(III ТҮВШИН)**

**1. Ажлын байрны тодорхойлолт**

Зам барилгын машин, тоног төхөөрөмжийн найдварт ажиллагааг ханган, ашиглалтын хугацааг нэмэгдүүлэхийн тулд түүнийг суурилуулж, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны шаардлага дүрэм журмыг баримтлан өмнөх (II) түвшингийн ажлын тодорхойлолтод заасан ажилбаруудаас гадна хөдөлгүүрийн тосолгоо, хөргөлтийн систем, тоормосны системд техник үйлчилгээ, засвар хийнэ.

Монгол Улсын Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт дахь мэргэжлийн индекс	СТ7233-11
Олон улсын ажил мэргэжлийн ангилал	СТ7233-11
Боловсруулсан огноо	2016 оны 09 – р сарын 21
Баталсан байгууллага	Уул уурхай, барилга замын машин эзэмшигчдийн холбоо
Баталсан огноо	2016 оны 12 – р сарын 21
Хянан засварлах хугацаа	YAMAT – д өөрчлөлт орох бүр, эсвэл 2 жил тутам

**2. Ажлын байрны тухай мэдээлэл**

**2.1. Ажлын байрны нөхцөл ба стандарт**

- Завсарчины ажлын байранд тухайн ажилбарыг гүйцэтгэхэд шаардлагатай хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагын дагуу гаргасан ажлын талбай, гэрэлтүүлэг, дулаацуулга, агааржуулалт, дуу чимээ, тоосжилт хэвийн хэмжээнд байна
- Технологийн картын дагуу шаардагдах технологийн тоног төхөөрөмж, багаж, нэмэлт хэрэгсэлээр иж бүрэн тоноглогдсон байна
- Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны болон галын аюулгүйн анхааруулах тэмдэг санамж тавигдсан байна
- Зам барилгын машины агрегат, зангилаа, эд ангийг задалж, засвар хийх нөхцөлд технологийн угаалга, тоосгүйжүүлэх ажилбарыг заавал хийх шаардлагатай
- Тоос шороо утаа зэрэг гадны нөлөөгүй галын аюулгүй байдлыг хангасан орчинг бүрдүүлэх ба сэлбэг, эд ангиудыг хадгалах тавиур болон шүүгээ тавигдсан байна.

- Шалны гадаргууг тос болон хөргөх шингэн чийгэнд тэсвэртэй материалаар өнгөлж тэгшилсэн байна.

## **2.2. Хөдөлмөр эрхлэлт ба тавигдах шаардлага**

18 нас хүрсэн эрүүл мэндийн үзлэгээр орсон ХАБЭА-н зааварчилга сургалтанд хамрагдаж суусан Монгол улсын Хөдөлмөрийн яам Мэргэжлийн холбооноос баталсан ажил мэргэжлийн түвшингийн 2-с доошгүй зэргийг хангасан мэдлэг ур чадварыг эзэмшсэн мэргэжилтэй ажилчин байна.

Зам барилгын машины засварчины ажлын нөхцөлд ажлын 8 цагаас илүүгүй ажиллах ба Эрэгтэй хүн 20 кг илүүгүй эмэгтэй хүн 10 кг илүүгүй хүнд эд ангийг өргөж суурилуулж ажиллах ба илүү гарсан жинтэй ачааг өргөн тээвэрлэх машин төхөөрөмжөөр хангагдсан байна.

### **2.2.1. Албан боловсрол**

Суурь ба түүнээс дээш боловсрол эзэмшсэн хүн

Мэргэжлийн сургалтанд хамрагдсан хүн

### **2.2.2. Мэдлэг**

- Хөдөлмөрийн хууль байгууллагын дотоод журам, холбогдох зааварчилгаа
- Зам барилгын машин, тоног төхөөрөмжийн засварчны ажлын байрны аюулгүй ажилгааны дүрэм журам, ажлын байрны зохион байгуулалтын онцлог
- Цэвэрлэгээний бодисын зориулалт, ашиглах заавар
- Түлхүүр багаж, хэмжээст түлхүүрний зориулалт ашиглалт
- Машин механизмыг зүгшрүүлэх, тохируулах арга
- Машин механизмд хийх мото цагийн техник үйлчилгээ
- Кинематик, цахилгаан, гидравлик, пневматик схем, тэмдэглэгээ

### **2.2.3. Ур чадвар**

- Хөдөлмөрийн хууль байгууллагын дотоод журам холбогдох зааварчилгааг мөрдөх
- Зам барилгын машин, тоног төхөөрөмжийн засварчны ажлын байрны аюулгүй ажилгааны дүрэм журам, ажлын байрыг зохион байгуулах
- Машин механизмыг жолоодон техник үйлчилгээ, засвар хийх постон дээр байрлуулах
- Цэвэрлэгээний бодисын зориулалт, ашиглах зааврыг мөрддөг байх
- Даралтаар ажилладаг шингэний ба хийн дамжуулагатай багажыг ашиглах
- Түлхүүр багаж, хэмжээст түлхүүрийг зориулалтын дагуу ашиглах
- Машин механизмыг зүгшрүүлэх, тохируулах



- Машин механизмд мото цагийн техник үйлчилгээ хийх
- Машин механизмд мото цагийн засварын гарыг авлага ашиглах
- Кинематик, цахилгаан, гидравлик, пневматик схем, тэмдэглэгээг унших
- Ажлын байранд гарах бэртэл, гэмтэлд анхан шатны тусламж үзүүлэх
- Аливаа машин, тоног төхөөрөмжийн ажиллагааг хурдан эзэмших, ажлын байранд тээвэрлэх
- Шинэ техник технологи, багаж хэрэгсэл эзэмших
- Тосолгооны системийн техник үйлчилгээ хийх
- Хөдөлгүүрийн гавлын эд ангийг задлаж, угсрах
- Хөдөлгүүрийн ремень, гинжин дамжуулгын техник үйлчилгээ хийх
- Явах ангид техник үйлчилгээ, засвар хийх
- Тоормосны системд техник үйлчилгээ, засвар хийх
- Ажлын төхөөрөмжид техник үйлчилгээ, засвар хийх
- Санаачлагатай, овсгоотой байх

#### 2.2.4. Хандлага

- Ээлжийн ахлагчийн өгсөн үүрэг даалгаварыг мөрдөж ажиллах
- Үнэнч шудрага байх
- Ажлын багийн гишүүд, хамт олонтой эелдэг боловсон харьцдаг байх
- Мэдлэг мэргэжлийн хувьд өсөх, дэвших сонирхолтой байх
- Бүтээлч сэтгэлгээтэй байх
- Ажлын гүйцэтгэлд хариуцлагатай ханддаг байх
- Ажлын ачаалал даах

#### 2.3. Хүлээх хариуцлага

Хэний өмнө хариуцлага хүлээх	Инженер, механик ээлжийн ахлах
Удирдан ажиллах ажилтан	Ээлжийн ахлагч

#### 2.4. Мэргэжил дээшлүүлэх болон хувиараа хөдөлмөр эрхлэх боломж

Холбогдох албан тушаалууд	Хөгжих дэвших боломж			Тусгай тэмдэглэл
	бага	дунд	өндөр	
Гүйцэтгэх албан тушаал		х		
Удирдах албан тушаал				байхгүй
Өөр төрлийн ажил үүрэг гүйцэтгэх боломж		х		
Хувиараа хөдөлмөр эрхлэх	х			

## 2.5. Үүрэг хариуцлага ба гүйцэтгэх ажлын даалгаврын жагсаалт

Үүрэг	Ажилбар
<b>Ажлын бэлтгэл хангах төлөвлөлт бэлтгэл ажил</b>	<p>Нэг бүрийн хамгаалах хэрэгсэлийг бүрэн өмссөн байх</p> <p>Аюулгүй ажилгааны дүрэм заасварт нийцүүлэн мөрдөж ажиллах</p> <p>Ээлжийн ахлагчаас тухайн өдрийн хуваарьт орсон техник үйлчилгээ, засвар ажлын даалгаварыг авна</p> <p>Засварын ажлын даалгаварт бичигдсэн (тухайн машин, техникийг хариуцсан операторын өгсөн мэдээллэх хуудасны дагуу) анхааруулгыг тусгаж ажиллах</p> <p>Тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай техникийн бичиг баримт, ашиглалтын заавартай танилцан ажлаа төлөвлөж бэлтгэлээ хангах</p> <p>Шаардлагатай бол тэмдэг тэмдэглэгээ, анхааруулах самбар байрлуулах, цоожлох, пайзлах арга хэмжээ авах</p> <p>Засварын ажилд шаардлагатай багаж, хэрэгслийг сонгох</p> <p>Засварын ажилд хэрэглэгдэх шалгаж тохируулах, задалж угсрах механик, цахилгаан, хийн ажиллагаатай төхөөрөмжийг ажилд бэлэн болгох</p>
<b>1. Засварчны ажлын байрыг зохион байгуулах</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Засварчны ажлын байрны аюулгүй ажиллагааны журам мөрдөх</li> <li>- Засварчны ажлын байран дахь тоног төхөөрөмж, засварын багажны ашиглалт, аюулгүй ажиллагааг хангах</li> <li>- Засварчны ажлын байрыг зохион байгуулах</li> <li>- Засварчны хувийн хамгаалах хэрэгслийн үүрэг, зориулалтыг судалж, ашиглах</li> </ul>
<b>2. Тосолгооны системд техник үйлчилгээ хийх</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Тосны түвшинг шалгах, техник үйлчилгээ хийх</li> <li>- Хөдөлгүүрийн тос солих</li> <li>- Тосны насос задлаж угсрах</li> <li>- Тосны насосны сальник солих</li> <li>- Тосны бүдүүн шүүр /тос хүлээн авагч/ цэвэрлэх</li> <li>- Хурдны хайрцагны тосыг шалгах, техник үйлчилгээ хийх</li> <li>- Кардан голыг тослох, техник үйлчилгээ хийх</li> <li>- Ерөнхий дамжуулгыг тослох, техник үйлчилгээ хийх</li> </ul>
<b>3. Тахир гол шатуны механизмын эд ангид техник үйлчилгээ хийх</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Хуруувч резинийг оношлох, солих</li> <li>- Гавлын битүүмжлэлийг шалгах</li> <li>- Клапангийн үүр билүүдэх</li> <li>- Нударган голын сальник солих</li> <li>- Гавлын резин, жийргийг солих</li> <li>- Хөдөлгүүрийн дээд эд ангийг задлах, оношлох</li> <li>- Гавлын хэсгийн эд ангиудыг задлаж, угсрах</li> <li>- Хуваарилах гол болон лимбэн голыг тайлж авах, цэвэрлэх, солих</li> <li>- Оруулах гаргах хоолойг тайлж авах, цэвэрлэх, солих</li> <li>- Гаргах хоолойг тайлж авах, цэвэрлэх, солих</li> </ul>
<b>4. Хөдөлгүүрийн ремень, гинжин дамжуулгад</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Ремень дамжуулгын чангалгааг шалгах, тохируулах</li> <li>- Гинжин дамжуулгын чангалгааг шалгах, тохируулах</li> <li>- Гинжин дамжуулгын замыг шалгах</li> <li>- Ремень дамжуулгын чангалгааг оношлох, солих</li> </ul>

<b>техник үйлчилгээ хийх</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Гинжин дамжуулгын чангалгааг оношлох, солих</li> <li>- Гинжин дамжуулгын замыг оношлох, солих</li> </ul>
<b>5. Явах ангид техник үйлчилгээ хийх</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Явах ангийн арал техник үйлчилгээ хийх</li> <li>- Хөтлөх хөтлөгдөх тэнхлэгт техник үйлчилгээ хийх</li> <li>- Гүүшинд техник үйлчилгээ хийх</li> <li>- Жолооны механизмд техник үйлчилгээ хийх</li> <li>- Хийн дугуйт явах ангид гадна угаалга хийх</li> <li>- Хийн дугуйнд техник үйлчилгээ, засвар хийх</li> <li>- Гинжит явах ангид гадна угаалга хийх</li> <li>- Гинж чангалах, тохиргоо, тосолгоо хий</li> </ul>
<b>6. Тоормосны системд техник үйлчилгээ, засвар хийх</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Зогсоолын тоормосны наклад солих, тохиргоо, үйлчилгээ хийх</li> <li>- Зогсоолын тоормосны тросс солих</li> <li>- Тоормосны системээс хий авах, шингэн солих</li> <li>- Дискэн тоормосны пиланз оношлох, солих</li> <li>- Барабант тоормосонд техник үйлчилгээ, тохиргоо хийх</li> <li>- Дискэн тоормосны системд техник үйлчилгээ, тохиргоо хийх</li> <li>- Дискэн болон барбант тоормосны наклад солих</li> <li>- Тоормосны төв аппарат, хүчлүүрт үзлэг хийх, засварлах, солих</li> </ul>
<b>Ажлын гүйцэтгэлээ мэдээллэх</b>	<p>Техник үйлчилгээ, засвар хийсний дараа тухайн узель зангилааны техникийн төлөв байдал норматив хэмжээнд хүрсэн эсэхийг нотлох</p> <p>Техник үйлчилгээ, засварын бүртгэлийн дэвтэр дээр хийсэн ажил, сольж тавьсан эд анги, узель зангилааны талаар бичилт хийнэ</p> <p>Ээлжийн ахлагч болон машин, төхөөрөмж хариуцсан операторт техник үйлчилгээ, засварын ажлын даалгаварт өгөгдсөн ажлын биелэлтийг мэдээллэх</p> <p>Техник үйлчилгээ, засвар хийж дууссаны дараа пайз, цоож, анхааруулах тэмдэг тэмдэглэгээг авах</p>

## 2.6. Эрх мэдэл ба хариуцлага

<b>Эрх мэдэл</b>	<p>Техник үйлчилгээ засварын ажил хийхэд шаардлагатай багаж хэрэгсэл, сэлбэг материал, нэг бүрийн хамгаалах хэрэгсэлээр хангуулахыг шаардах</p> <p>Хийж гүйцэтгэсэн техник үйлчилгээ, засварын ажлын гүйцэтгэлд үнэлгээ дүгнэлт гаргуулах, түүнтэй танилцах</p> <p>Хос мэргэжил эзэмших чадамжийн сургалтанд хамрагдах өөрийн мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэжлийн зэрэг ахиулах сургаланд хамрагдах хүсэлт гаргах тус тус эрхтэй</p>
<b>Хариуцлага</b>	<p>Техник үйлчилгээ, засварын ажлын технологийн дараалал зөрчих</p> <p>Тос тосолгооны материал буруу сонгох, дутуу хийх, хэмжилт тохируулга буруу хийснээс алдаа гаргах</p> <p>Засварын цех, ажлын байрны аюулгүй ажилгааны дүрэм журмыг зөрчих</p> <p>Ээлжийн ахлагчийн өгөгдсөн үүрэг даалгаврыг графикт хугацаанд хийгээгүй тохиолдолд тус тус хариуцлага хүлээнэ</p>

**АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ  
ЗАМ, БАРИЛГЫН МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАРЧИН  
(IV ТҮВШИН)**

**1. Ажлын байрны тодорхойлолт**

Зам барилгын машин, тоног төхөөрөмжийн найдварт ажиллагааг ханган, ашиглалтын хугацааг нэмэгдүүлэхийн тулд түүнийг суурилуулж, туршиж хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны шаардлага дүрэм журмыг баримтлан өмнөх (III) түвшингийн ажлын тодорхойлолтод заасан ажилбаруудаас гадна хөдөлгүүрийн тэжээлийн систем, хий хуваарилах механизм, хүч дамжуулах анги, явах ангид техник үйлчилгээ, засвар хийнэ.

Монгол Улсын Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт дахь мэргэжлийн индекс	СТ7233-11
Олон улсын ажил мэргэжлийн ангилал	СТ7233-11
Боловсруулсан огноо	2016 оны 09 – р сарын 21
Баталсан байгууллага	Уул уурхай, барилга замын машин эзэмшигчдийн холбоо
Баталсан огноо	2016 оны 12 – р сарын 21
Хянан засварлах хугацаа	YAMAT – д өөрчлөлт орох бүр, эсвэл 2 жил тутам

**2. Ажлын байрны тухай мэдээлэл**

**2.1. Ажлын байрны нөхцөл ба стандарт**

- Завсарчины ажлын байранд тухайн ажилбарыг гүйцэтгэхэд шаардлагатай хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагын дагуу гаргасан ажлын талбай, гэрэлтүүлэг, дулаацуулга, агааржуулалт, дуу чимээ, тоосжилт хэвийн хэмжээнд байна.
- Технологийн картын дагуу шаардагдах технологийн тоног төхөөрөмж, багаж, нэмэлт хэрэгсэлээр иж бүрэн тоноглогдсон байна.
- Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны болон галын аюулгүйн анхааруулах тэмдэг санамж тавигдсан байна.
- Зам барилгын машины агрегат, зангилаа, эд ангийг задалж, засвар хийх нөхцөлд технологийн угаалга, тоосгүйжүүлэх ажилбарыг заавал хийх шаардлагатай.
- Тоос шороо утаа зэрэг гадны нөлөөгүй галын аюулгүй байдлыг хангасан орчинг бүрдүүлэх ба сэлбэг, эд ангиудыг хадгалах тавиур болон шүүгээ тавигдсан байна.

- Шалны гадаргууг тос болон хөргөх шингэн чийгэнд тэсвэртэй материалаар өнгөлж тэгшилсэн байна.

## **2.2. Хөдөлмөр эрхлэлт ба тавигдах шаардлага**

18 нас хүрсэн эрүүл мэндийн үзлэгээр орсон ХАБЭА-н зааварчилга сургалтанд хамрагдаж суусан Монгол улсын Хөдөлмөрийн яам Мэргэжлийн холбооноос баталсан ажил мэргэжлийн түвшингийн 2-с доошгүй зэргийг хангасан мэдлэг ур чадварыг эзэмшсэн мэргэжилтэй ажилчин байна.

Зам барилгын машины засварчины ажлын нөхцөлд ажлын 8 цагаас илүүгүй ажиллах ба Эрэгтэй хүн 20 кг илүүгүй эмэгтэй хүн 10 кг илүүгүй хүнд эд ангийг өргөж суурилуулж ажиллах ба илүү гарсан жинтэй ачааг өргөн тээвэрлэх машин төхөөрөмжөөр хангагдсан байна.

### **2.2.1. Албан боловсрол**

Суурь ба түүнээс дээш боловсрол эзэмшсэн хүн

Богино хугацааны мэргэжлийн сургалтанд хамрагдсан хүн

### **2.2.2. Мэдлэг**

- Хөдөлмөрийн хууль байгууллагын дотоод журам холбогдох зааварчилгааг судалж хүлээн зөвшөөрсөн байх
- Зам барилгын машин, тоног төхөөрөмжийн засварчны ажлын байрны аюулгүй ажилгааны дүрэм журам, ажлын байрны зохион байгуулалтын онцлогийг судалж мэдсэн байх
- Машин механизмыг жолоодон техник үйлчилгээ, засвар хийх постон дээр байрлуулах
- Цэвэрлэгээний бодисын зориулалт, ашиглах зааврыг мэддэг байх
- Даралтаар ажилладаг шингэний ба хийн дамжуулагатай багажыг ашиглах мэдлэгтэй байх
- Түлхүүр багаж, хэмжээст түлхүүрний зориулалт ашиглалтын мэдлэгтэй байх
- Машин механизмыг зүгшрүүлэх, тохируулах мэдлэгтэй байх
- Машин механизмд мото цагийн техник үйлчилгээ хийх мэдлэгтэй байх
- Машин механизмд мото цагийн засварын гарыг авлага ашиглах мэдлэгтэй байх
- Кинематик, цахилгаан, гидравлик, пневматик схем, тэмдэглэгээг уншдаг байх
- Ажлын байранд гарах бэртэл, гэмтэлд анхан шатны тусламж үзүүлэх чадвартай байх

### 2.2.3. Ур чадвар

- Аливаа машин, тоног төхөөрөмжийн ажиллагааг хурдан эзэмших, ажлын байранд тээвэрлэх
- Шинэ техник технологи, багаж хэрэгсэл эзэмших
- Ажлын ачаалал даах
- Харилцаа
- Асуудал шийдвэрлэх
- Багаар ажиллах
- Хувийн менежмент
- Санаачлагатай, овсгоотой байх
- Ажлын ур дарын хөдөлгөөний мэдрэмж сайтай байх
- Суралцах

### 2.2.4. Хандлага

- Ээлжийн ахлагчийн өгсөн үүрэг даалгаварыг мөрдөж ажиллах
- Үнэнч шудрага байх
- Ажлын багийн гишүүд, хамт олонтой эелдэг боловсон харьцдаг байх
- Мэдлэг мэргэжлийн хувьд өсөх, дэвших сонирхолтой байх
- Бүтээлч сэтгэлгээтэй байх
- Ажлын гүйцэтгэлд хариуцлагатай ханддаг байх

### 2.3. Хүлээх хариуцлага

Хэний өмнө хариуцлага хүлээх	Инженер, механик ээлжийн ахлах
Удирдан ажиллах ажилтан	Ээлжийн ахлагч

### 2.4. Мэргэжил дээшлүүлэх болон хувиараа хөдөлмөр эрхлэх боломж

Холбогдох албан тушаалууд	Хөгжих дэвших боломж			Тусгай тэмдэглэл
	бага	дунд	өндөр	
Гүйцэтгэх албан тушаал			х	
Удирдах албан тушаал		х		
Өөр төрлийн ажил үүрэг гүйцэтгэх боломж		х		
Хувиараа хөдөлмөр эрхлэх	х			

## 2.5. Үүрэг хариуцлага ба гүйцэтгэх ажлын даалгаврын жагсаалт

Үүрэг	Ажилбар
<b>Ажлын бэлтгэл хангах төлөвлөлт бэлтгэл ажил</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Нэг бүрийн хамгаалах хэрэгсэлийг бүрэн өмссөн байх</li> <li>- Аюулгүй ажилгааны дүрэм заасварт нийцүүлэн мөрдөж ажиллах</li> <li>- Ээлжийн ахлагчаас тухайн өдрийн хуваарьт орсон техник үйлчилгээ, засвар ажлын даалгаварыг авна</li> <li>- Засварын ажлын даалгаварт бичигдсэн (тухайн машин, техникийг хариуцсан операторын өгсөн мэдээллэх хуудасны дагуу) анхааруулгыг тусгаж ажиллах</li> <li>- Тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай техникийн бичиг баримт, ашиглалтын заавартай танилцан ажлаа төлөвлөж бэлтгэлээ хангах</li> <li>- Шаардлагатай бол тэмдэг тэмдэглэгээ, анхааруулах самбар байрлуулах, цоожлох, пайзлах арга хэмжээ авах</li> <li>- Засварын ажилд шаардлагатай багаж, хэрэгслийг сонгох</li> <li>- Засварын ажилд хэрэглэгдэх шалгаж тохируулах, задалж угсрах механик, цахилгаан, хийн ажиллагаатай төхөөрөмжийг ажилд бэлэн болгох</li> </ul>
<b>1. Засварчны ажлын байран дахь тоног төхөөрөмж, засварын багажны ашиглалт, аюулгүй ажиллагааг хангах</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Засварчны ажлын байран дахь тоног төхөөрөмж, засварын багажны ашиглалт, аюулгүй ажиллагааг хангах</li> <li>- Галын аюулгүй байдлын болон урьдчилан сэргийлэх дүрэм, журмыг мөрдөж ажиллах</li> <li>- Анхан шатны тусламж үзүүлэх</li> </ul>
<b>2. Хөдөлгүүрийн үндсэн цахилгаан тоноглолд техник үйлчилгээ хийх</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Аккумулятор, генераторт хийх техник үйлчилгээ</li> <li>- Бензин хөдөлгүүрийн түлш цацалтын системд техник үйлчилгээ хийх</li> <li>- Мэдрэгчүүдийн ажиллагааг шалгах, солих</li> <li>- Дизель хөдөлгүүрийн цахилгаан тоноглолд үйлчилгээ хийх</li> <li>- Асаах системийг засварлах</li> <li>- Асаалтын системийг засварлах</li> <li>- Дизель хөдөлгүүрийн цахилгаан тоноглолд засвар хийх</li> <li>- Бензин хөдөлгүүрийн түлш цацалтын системийг засварлах</li> </ul>
<b>3. Автомашины гэрэлтүүлэх системд техник үйлчилгээ хийх</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Автомашины гэрэлтүүлэх системийг судлах</li> <li>- Гэрэлтүүлэх системийн эд ангийг задлаж, угсрах</li> <li>- Гэрэлтүүлэх системийн схем, тэмдэг тэмдэглэгээг унших</li> <li>- Эргэх дохио болон ослын дохионы гэрлийн ажиллагааг шалгах</li> <li>- Манан, ухрахын болон бүхээгний гэрлийн ажиллагааг шалгах</li> </ul>

<p><b>4. Бүхээгний агааржуулалтын системийг оношлох, засварлах</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Сэрүүцүүлэх болон халаах системийн бүхээгний агаар шүүгч цэвэрлэх</li> <li>- Кондейшн цэнэглэх</li> <li>- Кондейшний ремень дамжуулгыг шалгах, солих тохируулах</li> <li>- Өндөр даралтын мэдрэгчийг шалгах</li> <li>- Сэрүүцүүлэх болон халаах системийн бүхээгний агаар шүүгч солих</li> <li>- Сэрүүцүүлэх болон халаах системийг оношлох, засварлах</li> <li>- Кондейшны моторыг оношлох, солих</li> <li>- Сэрүүцүүлэх болон халаах системийн удирдлагыг тохируулах, засварлах</li> </ul>
<p><b>5. Хий хувиарлах механизмд техник үйлчилгээ хийх</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хуруувч резинийг оношлох, солих</li> <li>- Гавлын битүүмжлэлийг шалгах</li> <li>- Клапангийн үүр билүүдэх</li> <li>- Нударган голын сальник солих</li> <li>- Гавлын резин, жийргийг солих</li> <li>- Хөдөлгүүрийн дээд эд ангийг задлах, оношлох</li> <li>- Гавлын хэсгийн эд ангиудыг задлаж, угсрах</li> <li>- Хуваарилах гол болон лимбэн голыг тайлж авах, цэвэрлэх, солих</li> <li>- Оруулах гаргах хоолойг тайлж авах, цэвэрлэх, солих</li> <li>- Гаргах хоолойг тайлж авах, цэвэрлэх, солих</li> </ul>
<p><b>6. Хөргөлтийн системд засвар хийх</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хөргөлтийн системийн эд анги, ажиллагааг шалгах, засварлах</li> <li>- Усны насос, термостат, радиатор, сэнс шалгах, засварлах</li> <li>- Хөргөлтийн системийн шингэний дамжуулах уян хоолой, салоны халаалтын радиаторыг шалгах, засварлах</li> <li>- Хөргөлтийн системээс хий авах</li> <li>- Усны насос, термостат, радиатор, сэнс шалгах, солих, засварлах</li> </ul>
